# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр Дугаар 284 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыгтус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөвсгөл нуур, эгийн голын сав газрын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 1 ширхэг автомашины 3 дахь удаагийн нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2.Автомашины худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

3.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Хөвсгөл нуур, эгийн голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ундармаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

3.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА

Боловсруулсан:
Хянасан:
Хувь:

0002

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн
284 дугаар тогтоолын хавсралт

## ХӨВСГӨЛ НУУР, ЭГИЙН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүрийн дугаар | Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | ТӨБЗГ-ын 2017 оны 515 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг) | Худалдах доод үнэ 50% бууруулж тогтоосон (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоёота Ландкруйзер-80,58-46 ХӨҮ, арал-FZJ800026549, | 1993/2005 | 264 942 | 23 675 695,00 | - | 5 000 000,00 | 2 500 000,00 |
| | **НИЙТ ДҮН** | **-** | **-** | **23,675,696.00 (хорин гурван сая зургаан зуун далан таван мянга зургаан зуун ерэн зургаан)** | **-** | **5,000,000.00 (таван сая)** | **2,500,000.00 (хоёр сая таван зуун мянган)** |